



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 07 дугаар
сарын 09 ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай

Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор улсын хэмжээнд эрчимжүүлэх, бүх түвшинд хүүхдийг аливаа осол, гэмтлээс сэргийлэх, аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагыг мөрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг өгч байна:

1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.1. Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд:

1.1.1. Хүүхдийг аливаа осол, гэмтлээс сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, аюулгүй ажиллагааны холбогдох стандарт шаардлагыг мөрдүүлэх, хүүхдийн тоглоомын байгууламж болон гадна тоглоомын талбайн техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангах, засвар үйлчилгээний байдалд хяналт, шалгалтыг улирал тутамд хийх;

1.1.2. Хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн мөлжлөгийн төрлөөр Монгол Улсын нэгдэн орсон олон Улсын гэрээ конвенц болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулах;

1.1.3. Цэцэрлэг, сургууль, хүүхдийн байгууллагын байрнаас 100 метр зайд архи, тамхи, согтууруулах ундаа худалдахгүй, үйлчлэхгүй байх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах, хаах хүртэл арга хэмжээ авах;

1.1.4. Стандартын улсын үзлэг зохион байгуулж, шинэчлэх шаардлагатай стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэх ажлыг зохион байгуулах, хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангах асуудлаар салбар дундын үзлэг, шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулах;

1.1.5. Улсын баяр наадмын болон бүсийн хурдан морины уралдааны үеэр хүүхэд, иргэдийн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хурдан морь унаач хүүхдийн хууль тогтоомжоор заасан насны хязгаарыг баримталж, бүртгэлийг зохион байгуулах, хамгаалалтын хувцас хэрэгслийг бүрэн хэрэглүүлэхэд хяналт тавих.

1.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц Цогзолмаад:

1.2.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 14, 16 дугаар зүйлд заасан дүрэм, журмыг баталж, чиг үүргээ биелүүлэх. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөтөлбөр, төлөвлөгөө гарган бүх шатны боловсролын байгууллагуудад мөрдүүлэх.

1.2.2. Гадаад улсад суралцаж байгаа монгол хүүхдүүдийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, холбогдох ТББ-ын шугамаар Монгол Улсын боловсролын стандартад нийцсэн ном сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах;

1.2.3. Урлаг, спортын томоохон арга хэмжээний үеэр хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллах.

1.3. Эрүүл мэндийн сайд Д Сарангэрэлд:

1.3.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

1.3.2. "Сургуулийн насны хүүхдүүдийг сүрьеэгийн халдвараас урьдчилан сэргийлэхэд Д амин дэмийн нөлөө" судалгаатай холбоотой асуудлаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрүүл мэндийн яамны Анагаахын ёс зүйн хорооны дүгнэлтүүдийг судалж, шаардлагатай бол төслийг зогсоох хүртэл арга хэмжээ авах.

1.4. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц Нямдоржид:

1.4.1. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хүүхдийн эсрэг зөрчлийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан "Гэр бүл дэх хүүхэд хамгаалал", 6 дугаар зүйлд заасан "Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал", 7 дугаар зүйлд заасан "Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал", 8 дугаар зүйлд заасан "Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал", 9 дүгээр зүйлд заасан Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгааллын асуудалтай нийцүүлэх, эдгээр орчин дахь зөрчлийг шалган шийдвэрлэх асуудлыг тусгах;

1.4.2. Хүүхдийн эрх, аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах;

1.4.3. Хүүхдэд сөрөг нөлөөтэй бүх төрлийн контентыг тодорхойлж, насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээ тавих, хандалтыг хязгаарлах, устгах тогтолцоог бий болгох;

1.4.4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан "Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт

тавих журам"-д хил нэвтрээд эх орондоо эргэж ирээгүй хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчгүй хил нэвтрэхээр завдсан хүүхэдтэй холбоотой мэдээллийн дагуу холбогдох байгууллагууд хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой ажиллагаа явуулах асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах,

1.4.5. Баар, зочид буудал, саун массаж, цахим тоглоомын газруудын үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран улирал тутамд хяналт, шалгалт хийж, энэ төрлийн үйлчилгээ эрхлэгчдийн хүүхэд хамгааллын талаарх зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

1.5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт:

1.5.1. Хүүхдийн асрамж, халамжийн төвд өсч хүмүүжиж байгаа хагас, бүтэн өнчин хүүхдийг гэр бүл, түүнтэй дүйцэхүйц орчинд өсгөх асуудлаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан "Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээн"-д шаардагдах хөрөнгийг судалж, шийдвэрлэх;

1.5.2. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт заасан хүүхдийн зусланд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх журмын дагуу шаардагдах хөрөнгийг судалж, шийдвэрлэх.

1.6. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл нарт:

1.6.1. Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хагас бүтэн өнчин, асран хамгаалагчгүй 18 хүртэлх насны хүүхэд, залууст эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээг цогцоор үзүүлэх бүтцийг бий болгох.

1.7. Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт:

1.7.1. Замын засвар, үйлчилгээ, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээ, байгууламжийг стандартын дагуу барьж байгуулах ажлыг эрчимжүүлэх, хот хоорондын замд аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, хяналтыг сайжруулах;

1.7.2. Зам, тээврийн хөдөлгөөнд оролцоход хүүхэд болон явган зорчигчийг хамгаалах хэрэгслийн стандартыг шинээр нэвтрүүлэх.

1.8. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Барилга, хот байгуулалтын сайд Д.Баделхан нарт:

1.8.1. Уул уурхай, олборлолт, барилга, аялал жуулчлал, ойн болон хөдөө аж ахуй, газар тариалан, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай тухайн асуудлыг хариуцсан яам, агентлагаас байгуулах гэрээ, тусгай зөвшөөрөл олгох

журамд "Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

1.8.2. Уул уурхай, олборлолт, барилга, аялал жуулчлал, ойн болон хөдөө аж ахуй, газар тариалан, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг илрүүлж, судалгаа тоо гаргах;

1.8.3. Уул уурхай, олборлолт, барилга, аялал жуулчлал, ойн болон хөдөө аж ахуй, газар тариалан, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбар дахь ажлын талбайд эрсдэлийн үнэлгээ хийх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, дүрмийг мөрдөх, иргэд, хүүхдийг бэртэхгүй байхад анхаарах.

1.9. Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт:

1.9.1. Жил бүрийн 11 дүгээр сараас 3 дугаар сар хүртэлх агаарын бохирдол өндөр үед жирэмсэн эхчүүд болон бага насны хүүхдүүдийг агаарын бохирдлоос хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.

1.10. Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнд:

1.10.1. Цахилгааны үүсгүүр, цахилгаан дамжуулах шугам, трансформатор зэрэг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах, түгээх байгууламжуудын орчны хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ авах.

1.10.2. Эрчим хүчний тухай хууль тогтоомжуудад заасан хамгаалалтын зурвас, бүсийг чандлан тогтоох, хамгаалалтын бүсэд байгаа айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, сургууль, цэцэрлэг, хүүхдийн парк, хүүхдийн зуслангийн цахилгаан хангамжийн аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээ авах, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, харуул хамгаалалтыг сайжруулах, цахилгаан дамжуулах шугамд гарсан аливаа осол гэмтлийг шуурхай илрүүлэн тухай бүрт нь засварлаж аюул, эрсдэлгүй болгох ажлыг тогтмолжуулах.

1.11. Бүх шатны Засаг дарга нарт:

1.11.1. Үерийн ус зайлуулах далан суваг, инженерийн байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээг хийж, болзошгүй аюулаас сэргийлэх арга хэмжээ авах;

1.11.2. Замын далан, үхсэн нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд анхааруулах тэмдэг байршуулах, таглаж, битүүлэх;

1.11.3. Сургууль, цэцэрлэг, нийтийн эзэмшлийн биеийн тамирын болон хүүхдийн тоглоомын талбайн орчны гэрэлтүүлгийг сайжруулж, гадна, дотор орчныг камерын хяналтын системээр бүрэн хангах, эрсдэлтэй тоног төхөөрөмж, тоглоом хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулах;

1.11.4. Гэр хороолол, орон сууцны хорооллын дунд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, хүүхдийн амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд чиглэсэн хөгжлийн төвүүдийг байгуулах.

2. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон зарим Төрийн бус байгууллагын холбогдох удирдлагуудад зөвлөмж болгох нь:

2.1. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

2.1.1. Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүүхдийг аливаа осол, гэмтлээс сэргийлэх, аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагыг мөрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх байгууллага, албан тушаалтны сонголт, мэдээллийг сонсож, тодорхой, хугацаатай үүрэг даалгавар өгөх;

2.1.2. Орон нутагтаа Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх.

2.2. Төрийн байгууллагуудад:

2.2.1. Төрийн байгууллагуудад хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн зэрэг арга, гэр бүлийн харилцаа сэдвүүдээр сургалт, сонсголыг тогтмол зохион байгуулах, бүх байгууллагуудад "Эцэг эхийн зөвлөл" байгуулж, Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллуулах;

2.2.2. Албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлж, хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, дотоод, гадаад орчинд эрсдэлийн үнэлгээ хийж, хүүхдийн асуудлаар ямар нэгэн алдаа гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх.

2.3. Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэнд:

2.3.1. "Хүүхэд хамгааллын даатгал"-ын үйлчилгээ, "Хурдан морины уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгалын үйлчилгээ"-г олон нийтэд сурталчлан таниулж, хамгийн их эрсдэлтэй гэр бүлд амьдарч байгаа хүүхэд, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хурдан морь унаач хүүхдийг даатгаж, даатгалын тохиолдол буюу сураггүй алга болох, бүхий л төрлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрэн хайх, эрүүл мэндийг нөхөн сэргээх, тээвэрлэх, аюулгүй байдлыг хангах, хууль шүүхийн шатанд эрх зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн зардал зэргийг даатгалын компани нөхөн төлөх асуудлаар даатгалын компаниудтай хамтран ажиллах.

2.4. Монголын морин спорт уяачдын холбоонд:

2.4.1. Хөдөө, орон нутагт зөвшөөрөлгүй хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байх.

2.4.2. Уяачдад зориулан хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, сургууль завсардуулахгүй байх, хүмүүжлийн эерэг аргыг эзэмшүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, хурдан морины унаач хүүхдэд стандартад нийцсэн хамгаалалтын хувцас, хэрэгсэл хэрэглүүлэх.

2.5. Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн захирал Л.Нинжамцад:

2.5.1. Хүүхдийн насны онцлогт тохируулан асрах, хүмүүжүүлэх, мэдлэг, хандлагыг эцэг, эх, асран хамгаалагч нарт төлөвшүүлэх, олон нийтийг эерэг мэдээ, мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх байнгын цаг, хөтөлбөрийг бий болгож, нэвтрүүлэх.

3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, Гөрийн бус байгууллага, эцэг, эхчүүдэд Уриалах нь:

3.1. Хувийн хэвшлийн байгууллагуудад хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцаа сэдвүүдээр сургалт, сонсголыг тогтмол зохион байгуулах, бүх байгууллагуудад "Эцэг эхийн зөвлөл" байгуулж, Хүүхэд хамгааллын бодлогыг мөрдөж ажиллуулах;

3.2. Эцэг эх нь үүрэг хариуцлагаа ухамсарлаж хүүхдээ өөрсдийн хараа хяналтад байлгах, сонор сэрэмжтэй байж, хүүхдээ аливаа болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хүмүүжлийн эерэг аргаар хүүхдээ хүмүүжүүлэх, хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургах;

3.3. Эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээрх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, хамтран ажиллах;

3.4. Хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэх контентыг цацахгүй байх, зөв төлөвшил, ёс суртахуунтай Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд чиглэсэн контент бэлтгэж нэвтрүүлэх.

4. Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, улирал бүрээр дүгнэж, тайлангаа ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож байна.

5. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монголд Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт хариуцуулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд



ХҮРЭЛСҮХ